



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/546

Есөнбулаг сум

Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны "Тогтоолд нэмэлт хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" 84 дүгээр тогтоол, Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай" 37 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 39 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 26 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал зэрэглэлийг нэгдүгээр хавсралтаар, бүтэц орон тоо, зохион байгуулалтын схем зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Орон нутгийн өмчийн газрын шинээр батлагдсан бүтэц, орон тоонд багтаан шаардлагатай төсвийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү шийдвэр гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/654 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025

8200011595

10 Аймгийн Засаг даргын 2025 оны
... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэршил	Албан тушаалын төрөл	Албан тушаалын ангилал зэрэглэл	Орон тоо
1	Орон нутгийн өмчийн газрын дарга	Удирдах	Ахлах түшмэл ТЗ-4	1
2	Өмчийн удирдлага хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-8	1
3	Хууль, хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-9	1
4	Өмчийн удирдлага төлөөлөл хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-9	1
5	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-9	1
6	Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-9	1
7	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-9	1
8	Ерөнхий нягтлан бодогч	Гүйцэтгэх	ТҮМ-7	1
9	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Гүйцэтгэх	ТҮМ-3	1
10	Нярав, жолооч	Гүйцэтгэх	ТҮ-4	1

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 08 -ны өдрийн 44 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нийт орон тоо 10:

